



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/08

Мандалговь

“Эцэг эхийн зөвлөл”-ийн  
үйл ажиллагааг дэмжих тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, 18.1.6, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай” 03 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Аргачлал, зардлын норматив батлах тухай” А/23,27 тоот хамтарсан тушаалын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хамгаалъя хариуцлагатай байя” аяны хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхэдтэй зүй бус харилцах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалахад хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлүүдэд 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр сургалт зохион байгуулсугай.

2. Байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор зохион байгуулах ажлын хэсгийг; 1 дүгээр, шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах нийт 2,168,800 (хоёр сая нэг зуун жаран найман мянга найман зуун) төгрөгийн 1,080,000 (нэг сая наян мянга) төгрөгийг Гэр бүлд чиглэсэн хөтөлбөрөөс, 1,088,800 (нэг сая наян найман мянга найман зуун) төгрөгийг Урьдчилан сэргийлэх зардлаас тус тус санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Залуучууд хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн (Д.Мигар), гишүүдэд үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 02 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, Залуучууд хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн (Д.Мигар)-д даалгасугай.


ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

482301015

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,  
залуучуудын хөгжлийн газрын даргын  
2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн  
4/02 тоот тушаалын 01 дүгээр хавсралт



БАЙГУУЛЛАГЫН ДЭРГЭДЭХ "ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛ"-ИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Мигар

(Залуучууд хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа  
хариуцсан ахлах мэргэжилтэн)

Гишүүд:

Ш.Эрдэнэсүвд


(Хүүхдийн эрхийн улсын байцаагч)

Б.Биндэрьяа

(Архив, бичиг хэрэг хариуцсан ажилтан)

-----oOo-----

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,  
залуучуудын хөгжлийн газрын даргын  
2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн  
А/02 тоот тушаалын 02 дугаар хавсралт



БАЙГУУЛЛАГЫН ДЭРГЭДЭХ "ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛ"-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ  
ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

| 1. Гэр бүлд чиглэсэн хөтөлбөрөөс |                                   |             |                |            |           |
|----------------------------------|-----------------------------------|-------------|----------------|------------|-----------|
| №                                | Зардлын ангилал                   | Хэмжих нэгж | Нэг бүрийн үнэ | Тоо ширхэг | Нийт үнэ  |
| 1                                | Сургалтын хэрэглэгдэхүүн Гэр өрөг | ш           | 30,000         | 36         | 1,080,000 |
| Нийт                             |                                   |             |                |            | 1,080,000 |
| 2. Урьдчилан сэргийлэх зардлаас  |                                   |             |                |            |           |
| 1                                | Сургагч багшийн хөлс              | Хүн/тоо     | 2500           | 420        | 1,050,000 |
| 2                                | Скоч                              | ш           | 3900           | 4          | 15,600    |
| 3                                | Оёдолын утас                      | ш           | 5000           | 1          | 5,000     |
| 4                                | Цаасны цавуу                      | ш           | 1800           | 3          | 5,400     |
| 5                                | Хуруун зай                        | ш           | 1600           | 8          | 12,800    |
| Нийт                             |                                   |             |                |            | 1,088,800 |
| Нийт дүн                         |                                   |             |                |            | 2,168,800 |